



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 134

Чойр

Газар эзэмших эрхийг бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 52 дугаар зүйлийн 52.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Захираганы ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтууд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн "Ус-Ду" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нэгж талбарын 4201010577 дугаартай 15 метр квадрат газрыг 180,000 (нэг зуун наян мянга) төгрөгөөр, 4201010580 дугаартай 16 метр квадрат газрыг 160,000 (нэг зуун жаран мянга) төгрөгөөр, 4201010579 дугаартай 15 метр квадрат газрыг 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгөөр, 4201010578 дугаартай 16 метр квадрат газрыг 160,000 (нэг зуун жаран мянга) төгрөгөөр, 4201010573 дугаартай 624 метр квадрат газрыг 7,488,000 (долгоон сая дөрвөн зуун наян найман мянга) төгрөгөөр, 4201010581 дугаартай 16 метр квадрат газрыг 160,000 (нэг зуун жаран мянга) төгрөгөөр, 4201010582 дугаартай 17 метр квадрат газрыг 170,000 (нэг зуун далан мянга) төгрөгөөр тус тус бодит үнэ цэнийг санхүүгийн тайлагналлын зориулалтаар үнэлсэн тул үндсэн хөрөнгөд бүртгэхийг аймгийн Засаг дарга (Г.Батзам)-д зөвшөөрсүгэй.

2. Дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг холбогдох байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналтын дор эд хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Эд хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг эрх бүхий байгууллагаас баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн "Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн жилийн мэдээ" маягтын дагуу гаргаж хуулийн хугацаанд Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 04 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Ж.Оюунбилэг)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.БИЛЭГТҮМБЭРЭЛ

